

Маягт нөхөх товч заавар:

Объектын өмчийн төрөл (5-р багана)-д барилгын захиалагч улсын байгууллага-1, хувийн- 2 гэсэн тоог нөхнө.

Объектын регистр, объектын өмчийн төрлийг тухайн аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд мэдээг дамжуулахдаа бөглөнө. Объектын гүйцэтгэгч болон захиалагч солигдоход объектын регистр өөрчлөгдөхгүй, нэг объект баригдах хугацааныхаа туршид нэг регистртэй байхыг анхаарна уу!

Барилгын төрөл (6-р багана) нь дотроо 3 бүлэгт хуваагдах бөгөөд

Орон сууцны барилгын хувьд

угсармал	2
тоосгон	3
блокон	4
бусад	5

Орон сууцны бус барилгын хувьд

үйлдвэрийн зориулалттай	6
худалдаа үйлчилгээний	7
зочид буудал	8
эмнэлэг	9
сүм хийд	10
сургууль соёлын	11
конторын зориулалттай	12
агуулах, гараажийн зориулалттай	13

Инженерийн барилгын хувьд

эрчим хүчний	14
холбооны	15
төмөр зам	16
авто зам	17
гүүр, гүүрэн гарц	18
далан, суваг, шугам	19
бусад зам талбай	20

Их засварын ажлын хувьд

орон сууцны	22
орон сууцны бус	23
инженерийн барилга	24

гэсэн тоонуудыг тус тус бөглөнө.

Хүчин чадлын биет хэмжээг орон сууцны барилгын хувьд хаалгаар буюу айлаар, орон сууцны бус үйлдвэрийн барилга, худалдаа, үйлчилгээний барилгыг м²-аар, зочид буудал, эмнэлгийн барилгын хувьд ороор, сургууль, соёлын барилгыг суудлаар, контор (албан тасалгааны) зориулалттай барилгын хувьд м²-аар, гаражийг машины тоогоор, инженерийн барилгын байгууламжийн хувьд эрчим хүчний барилга, объектыг кВт-аар, холбооны барилгыг м²-аар, төмөр замыг төмөр замын уртаар буюу м²-аар, харин төмөр замын орон сууцны барилгыг айлаар, албан конторын зориулалттай бол м²-аар гэх мэтчилэн холбогдох төрөлд нь оруулна, замын уртыг км-ээр, замд хийсэн нөхөөсийг м²-аар, гүүрийг м-ээр, далан, сувгийг м-ээр, шугам, сүлжээг кВт, км-ээр тус тус бөглөнө.

Барилгын нийт талбайг барилгын зурагт заасан байдлаар (ханын дотор талын урт ба өргөний үржвэрийн нийлбэрээр), эзэлхүүнийг тухайн барилгын урт, өндөр, өргөн 3-н үржвэрээр тодорхойлно.

Үндсэн фонд гэдэг нь барилга, объектыг барьж эхэлсэнээс хойш ашиглалтанд оруулах хүртэлх хугацаанд гарсан нийт өртгийн нийлбэртэй тэнцүү байна.